



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 46,298,394.00 (дөчин зургаан сая хоёр зуун ерэн найман мянга гурван зуун ерэн дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2.Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Ч.Аюушмаад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оролцуулан дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2022 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 2 дугаар сарын 0-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

**ДОРНОД АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН**

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар | Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл | Шинэчлэн тогтоосон үнэ |
|-----|--|--|-----------------------|--|---------------------------|
| | | | | /төгрөг/ | |
| 1 | Ачааны автомашин DONGFENG CLW5050 XLC38 LGDTK81G29A159787, улсын дугаар 7129 ДОР | 2009/2010 | 265321 | 46,298,394.00 | 1,000,000.00 |
| | | | | 46,298,394.00 | 1,000,000.00 |
| | НИЙТ ҮНЭ | | | (дөчин зургаан сая хоёр зуун ерэн найман мянга гурван зуун ерэн дөрвөн) | (нэг сая) |